

байрлуулах гурван хэмжээст зураг бүхий дижитал баганыг бүтээсэн байна.

Монгол Улс, Холбооны Бүгд найрамдах Герман Улсын Харилцаа, хамтын ажиллагааны хөгжил дэх Европын Холбооны хүчин зүйл

Доктор (Sc.D) Олхонууд Р.Жамц
ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан

Монгол Улс, ХБНГУ-ын өнөөгийн харилцаа хамтын ажиллагаанд Монгол-Европын Холбоо(ЕХ)-ны харилцаа чухал хүчин зүйл болж байна. Өнөө үед Европын орнууд ЕХ-ны хүрээнд интеграцчилагдах үйл явцад гүнзгий орж байна. Дундад зууны үеэс үүсэлтэй Европын нэгдлийн үзэл санаа дэлхийн II-р дайны дараа эрчээ авч, 1947, 1949 онд байгуулагдсан Бенилюксын гэрээ, 1951 онд Европын Нүүрс, Гангийн Нийгэмлэг, 1957 онд байгуулагдсан Европын Атомын Эрчим Хүчний Нийгэмлэг, Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг зэрэг нь 1992 онд ЕХ байгуулагдахад нэгэн чухал түлхэц болсон юм.

2002 он хүртэл уг холбоонд Европын 15 орон багтаж байсан бол 2004 оноос энэ эгнээ өсч эдүгээ 25 орон болоод байна. Өнөө үед энэхүү асар том бүтэц 374 сая хүн амтай, нэг хүнд ногдох Үндэсний Нийт Бүтээгдэхүүний дундаж нь 20.000 ам долларт хүрч, худалдааны нийт эргэлтээрээ дэлхийд 2 дугаар байранд ордог, дэлхийн нийт үйлдвэрлэлийн 19,8 хувийг 2000 онд үйлдвэрлэсэн нь АНУ-ын дараа хоёрдугаарт орж байна. ЕХ-г байгуулах тухай Маастрихтын 1992 оны гэрээний дагуу ЕХ нь нэгдсэн зах зээл, валютын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь ЕХ дэлхийн эдийн засагт төдийгүй улс төрийн харьцаанд нөлөө үзүүлж чадахуйц томоохон хүчин болохыг харуулж байна. 2004 онд ЕХ-ны үндсэн хуулийг боловсруулсан билээ. Дэлхийд эзэлж буй байр суурь, гүйцэтгэж буй үүрэг нь улам бүр нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд ЕХ-той Монгол Улс харилцаа, хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлэх нь манай орны хувьд гадаад бодлогын чухал чиглэлийн нэг болж байна.

1980 оноос бүрэлдэн буй болсон гадаад, дотоод таатай нөхцөл

нь Монгол Улс 1989 оны 8 дугаар сард ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоох боломж олгожээ.

Монгол Улс, ЕХ-ны харилцаа, хамтын ажиллагаа 1989 оноос хойш улс төр, эдийн засаг, хөгжлийн тусламж гэсэн үндсэн гурван чиглэлээр хөгжих боллоо. Энэ хугацаанд Монгол улсын Ерөнхийлөгч 2 удаа, Ерөнхий сайд 3 удаа, Их хурлын дарга 2 удаа тус тус ЕХ-нд айлчилсан байна. ЕХ-ны удирдлагуудаас ч Монголд айлчилсан байна.

Монгол Улс, ЕХ-ны харилцааны эрх зүйн үндэс ч тавигдсан байна. Монгол Улс нь ЕХ-той

- Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг 1992 онд,
- Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн худалдаалах тухай хэлэлцээрийг 1995 онд (1998 онд энэ хэлэлцээрийн хугацааг сунгасан),
- Европын Хөрөнгө Оруулалтын банкттай хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг 1997 онд тус тус байгуулж,
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банкны гишүүнээр 2000 онд элссэн байна.

ЕХ-ны тусламж: ЕХ-ны АПА, ТАСИС хөтөлбөрийн хүрээнд 1992 оноос хойш 55,2 сая гаруй еврогийн 90 орчим төслийг Монгол Улсад амжилттай хэрэгжүүлсэн байна.

Энэ тусламжийг дээд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуй, хөдөөгийн бөөний худалдааны сүлжээ, мал эмнэлэг, жижиг дунд үйлдвэр, эрчим хүч (сэргээгдэх эрчим хүч), тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, мэдээллийн технологи, стандарт, хэмжил зүй, чанар, статистик, гааль зэрэг салбарыг бэхжүүлэх, Засгийн газрын бус байгууллагуудыг дэмжих, хостуудын түншлэлийн чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна. ЕХ-ны Ази, Латин Америкийн орнуудад зориулсан АПА хөтөлбөрийн хүрээнд 1992-1993 онд мал эмнэлгийн албадыг бэхжүүлэх, стандартчилал, хэмжил зүй, чанарын хяналтын удирдлагын салбарыг хөгжүүлэх, менежментийг хөгжүүлэх, Зах зээл судлалын хүрээлэнг дэмжих, сургалт явуулахад нийтдээ 8 сая евро буюу 10 орчим сая ам.долларын өртөг бүхий төслүүдийг Монголд хэрэгжүүлсэн.

АПА хөтөлбөрийн дээрхи төслүүдийг 1991 онд Улаанбаатар

хотноо зохион байгуулсан Хандивлагчдын анхдугаар зөвлөлгөөний үед тохиролцож шийдвэрлэсэн боловч зарим төсөл, тухайлбал "Стандартчилал, хэмжил зүй, чанарын хяналтын удирдлагын салбарыг хөгжүүлэх" төсөл 1997 оны 10 дугаар сараас 2001 он хүртэл үргэлжилсэн байна.

ТАСИС хөтөлбөрийг Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн орнуудад шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжихэд техникийн туслалцааг буцалтгүй тусламжаар үзүүлэх зорилготойгоор ЕХ 1990 оноос санаачилсан юм.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан орнуудад зориулсан тусгай хөтөлбөр болох ТАСИС-т нэгдэж орох нь манай оронд илүү тохиромжтой гэж Засгийн газраас 1993 оны 11 дүгээр сард шийдвэрлэсний дагуу манай улс 1994 оны 1 дүгээр сараас ТАСИС хөтөлбөрт хамрагдах болсон.

ТАСИС хөтөлбөрийн хүрээнд гадаадын зөвлөх экспертүүд ажиллуулах, гадаад, дотоодод сургалт явуулах, танилцах аялал зохион байгуулах, тоног төхөөрөмж, сургалтын материал ирүүлэх, зарим тодорхой объектын хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг үндсэн ажлуудыг хийж ирсэн.

ТАСИС хөтөлбөрийн туншлэгч орнуудад 1996-1999 оны хугацаанд хуваарилсан хөрөнгө, нэг хүнд ногдох хэмжээнээс харахад Монгол Улсын нэг хүнд ногдох тусламжийн хэмжээ 8,9 евро буюу 9,49 ам.доллар болж, ТАСИС хөтөлбөрийн орнуудын дотор энэ үзүүлэлтээр нэгдүгээр байранд байсан байна.

ТАСИС хөтөлбөрийн шугамаар ЕХ-ноос Монгол Улсад нийт 40,5 сая евро-гийн (1994-1995 онд 8,0 сая евро, 1996-1997 онд 9,5 сая евро, 1998-1999 онд 11,0 сая евро, 2000-2001 онд 6,0 сая евро, 2002-2003 онд 6 сая евро) буцалтгүй тусламж олгосон. Уг хөтөлбөрийн хүрээнд хөдөөгийн эдийн засгийн хөгжил, хувийн секторыг дэмжиж, эдийн засгийг хөгжүүлэх, шилжилтийн үеийн нийгмийн үр дагаврыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр 2000-2003 онд тодорхой төслүүдийг Монгол Улсад хэрэгжүүлсэн. Сүүлийн жилүүдэд хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх асуудал нь ЕХ-ны ТАСИС хөтөлбөрөөс Монгол Улсад үзүүлж буй тусламжийн үндсэн гол чиглэл болжээ.

ЕХ-ноос ТАСИС хөтөлбөрийг 2006 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.

Европын Комисс ЕХ-ноос Монгол Улсад үзүүлэх тусламж, дэмжлэгийн стратегийг тодорхойлж, 2002-2006 онд мөрдөгдөх Үндэсний Стратегийн Баримт (Country Strategy Paper) бичгийг 2001 оны 12 дугаар сарын 27-нд баталсан. Үндэсний Стратегийн Баримт бичгийн хүрээнд Үндэсний Баримжаалсан хөтөлбөр (National Indicative Programme) батлан гаргадаг бөгөөд 2004-2006 оны хөтөлбөрийг одоо хэрэгжүүлж байна.

Уг баримжаалсан хөтөлбөрт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын боломжийг нэмэгдүүлэх, түүнчлэн ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас олгох зээлд хувь нэмэр оруулах замаар Монголын өөрчлөлт, шинэчлэлд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон. Дээрх чиглэлээр 2004-2006 онд 9 сая еврогийн тусламж үзүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр тусгасан.

Манай улс 2004 оны 1 дүгээр сараас Европын Комиссын Ази, Латин Америкийн орнуудад зориулсан тусламжийн АЛА хөтөлбөрт хамрагдах болсон. АЛА хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны өргөн цар хүрээтэй, урт хугацааны төслүүд хэрэгжүүлэх сайн талтай байв.

2005 оноос Монгол Улс Европын Комиссоос зохион явуулж буй магистрын тэтгэлэг олгох "Иразмус Мундус" (Erasmus Mundus) хөтөлбөр болон дээд боловсролын байгууллагуудыг дэмжих "Эйжа Линк" (Asia link) хөтөлбөрт хамрагдсан.

Хүмүүнлэгийн тусламж: 1993-1994 онд анх удаа Монгол Улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн бөгөөд нийтдээ 3,8 сая еврогийн улаан буудайн гурилыг Олон улсын улаан загалмай, Хавирган сар Нийгэмлэг, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын шугамаар нийлүүлсэн.

Монгол оронд учирсан зудын гамшгийг арилгахад тусламж болгон 2000 онд 1,3 сая евро, 2001 онд 575 мянган евро олгосон бөгөөд 2001 оны 3 дугаар сард 1,03 сая еврогийн тусламж үзүүлэх шийдвэрийг Европын Парламентаас гаргасан билээ.

Европын Комиссын хүмүүнлэгийн тусламжийн

байгууллагаас Монголын Улаан загалмайн нийгэмлэгээр уламжлан нийт аймгуудад, Европын зарим төрийн бус байгууллагын туслалцаатайгаар Увс, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл зэрэг аймгуудын зудад нэрвэгдсэн айл өрхийн 2-3 сарын хүнсний хэрэгцээг хангахад хурэлцэхүйц хэмжээний гурил, цагаан будаа, ургамлын тос болон дулаан хөнжил, газар тариалан эрхлэхэд шаардагдах багаж хэрэгслэл нийлүүлэх ажил 2000-2001 оны өвөл, хаврын улиралд хийгдсэн. 2004 онд ЕХ-ны хүмүүнлэгийн тусламжийн байгууллагаас Монгол Улсын гамшигтай тэмцэх хөтөлбөрт зориулж 1 сая евро олгохоор шийдвэрлэсэн.

Монгол Улс, ЕХ-ны хамтын ажиллагааны хамтарсан хороо:

Монгол Улс, ЕХ-ны хамтарсан хороо Монгол-ЕХ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны 1992 оны хэлэлцээрийн дагуу уг хэлэлцээрийн хэрэгжилтийг хянаж дүгнэх, худалдаа, эдийн засгийн харилцаа, хөгжлийн хамтын ажиллагааны явцад үнэлгээ өгөх, хэлэлцээрт дурдсан салбаруудын асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, төрөлжүүлэх боломжийг хэлэлцэх, харилцан сонирхсон асуудлаар байр сууриа илэрхийлэх, санал солилцох зэрэг зорилгоор байгуулагдаж, анхны хуралдаанаа 1993 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо хийсэн.

Монгол-ЕХ-ны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 9 дүгээр хуралдаан 2006 оны 6 дугаар сарын 9-нд Улаанбаатар хотноо зохиогдсон. Хуралдаанд Монголын талаас оролцох төлөөлөгчдийг тус хамтарсан хорооны Монголын хэсгийн дарга, Монгол Улсын Шадар сайд М.Энхсайхан, ЕХ-ны төлөөлөгчдийг Европын Комиссын Гадаад харилцааны ерөнхий газрын Азийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч ноён Жэймс Моран нар тус тус тэргүүлж оролцов.

Хамтарсан хорооны 9 дүгээр хуралдаанаар Монгол Улс, ЕХ-ны улс төр, нийгэм эдийн засгийн байдал болон гадаад бодлогын талаар харилцан мэдээлэл хийж, Монгол-ЕХ-ны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн тоймтой асуудлууд, ойрын ирээдүйд хамтран хэрэгжүүлэх тодорхой төслүүд, ЕХ-ноос Монгол Улстай 2007-2013 онд хамтран ажиллах Стратегийн

баримт бичгийн төсөл, хамтын ажиллагааг цаашид хөдөөгийн хөгжил, боловсрол, хувийн хэвшлийг дэмжих, сэргээгдэх эрчим хүч, худалдаа, эдийн засгийн харилцааны салбарт хөгжүүлэх боломжийг хэлэлцэв.

Хамтарсан хорооны хуралдааны өмнө Худалдаа, хөрөнгө оруулалтын дэд хорооны хуралдааныг зохион явуулах бөгөөд тус хуралдаанаар ЕХ-ны худалдааны ерөнхий хөнгөлөлтийн "GSP Plus" системийн хүрээнд Монгол Улсад олгосон худалдааны хөнгөлөлтийг илүү үр дүнтэй ашиглах арга замууд, Монголын экспортын салбарын ялангуяа хөдөө аж ахуйн экспортын чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн техникийн хамтын ажиллагааны төслүүд болон хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн алхмуудын талаар санал солилцсон болно.

Хамтарсан хорооны хуралдааны үеэр ЕХ-ны Хамтын ажиллагааны газрыг Улаанбаатар хотноо албан ёсоор нээв.

Худалдаа, эдийн засгийн харилцаа: ЕХ-той хийсэн худалдаа сүүлийн 10 жилийн дунджаар манай улсын нийт гадаад худалдаанд 10 орчим хувийг эзэлж байна.

Монгол, ЕХ-ны хоорондын худалдаа 1995 онд 100,6 сая ам.доллар, 2000 онд 105,6 сая ам.доллар, 2003 онд 131,1 сая ам.доллар, 2004 онд 297,8 сая ам.доллар, 2005 онд 245 сая ам.долларт хүрэв.

Манай улс 2005 онд ЕХ-ны орнууд 131,4 сая орчим ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон байна.

Их Британи Улсад 81,9 сая ам.долларын үнэ бүхий боловсруулаагүй алт гаргасан нь ЕХ-нд нийлүүлсэн нийт экспортын 62 хувийг эзэлж байна. Монгол Улс ЕХ-ноос 2005 онд 113.5 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн импортолсон нь өмнөх оны түвшинд байна. ХБНГУ (29,3%), Франц (25.7%) улсад импортын ихэнх хувь ногдож байна.

ЕХ-той хийсэн худалдаа 2003 онд Монголын талд 61,5 сая ам.долларын алдагдалтай байсан бол худалдааны тэнцэл 2004 онд 75,2 сая ам.доллар, 2005 онд 17,9 сая ам.долларын ашигтай байлаа. Сайн засаглал, тогтвортой хөгжлийн болзлыг хангасан эмзэг буурай эдийн засагтай хөгжиж буй орнуудад ЕХ-ны зүгээс 2006-2008 онд олгох импортын "О" татвартай Худалдааны

Хөнгөлөлтийн Ерөнхий системийн шинэ журам батлагдаж, 2006 оны 7 дугаар сарын 1-нээс Монгол Улс "GSP Plus" хэмээх энэхүү хөнгөлөлтийг эдлэх орнуудын урьдчилсан жагсаалтад орсон. "GSP+" худалдааны хөнгөлөлтийг Монгол Улсад 2006-2008 онд үргэлжлүүлэн олгох тухай шийдвэрийг Европын Комисс 2005 оны 12 дугаар сарын 21-нд гаргасан. Ингэснээр тус хөнгөлөлтөд хамрагдсан 14 орны 7000 гаруй нэрийн барааг ЕХ-ны зах зээлд 2006-2008 онд гаалийн татваргүй оруулах боломж бий болж буй бөгөөд тэдгээрт оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг манай экспортын гол нэрийн бараа хамрагдаж байна. Манай улсыг худалдааны тусгай хөнгөлөлт "GSP+"-д хамруулсан нь хоёр талын худалдаа, ялангуяа Монголын экспортыг нэмэгдүүлэх таатай боломж олгосон чухал үйл явдал болсон.

Монгол Улсыг зах зээлийн эдийн засагтай орны жагсаалтад оруулах хүсэлтийг Европын Комисст төрөл бүрийн түвшинд тавьсан бөгөөд Европын Комисс нэмэлт мэдээлэл хүссэнийг 2005 оны 3 дугаар сард хүргүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт: 1991 оноос 2004 оны эцэс хүртэл хугацаанд Монгол Улсад 73 орны 3.868 компани 1,3 миллиард ам.долларын хөрөнгө оруулалт хийснээс БНХАУ, Канад, АНУ, БНСУ, Япон, ОХУ хөрөнгө оруулалтын хэмжээ болон компанийн тоогоор тэргүүлж байна. 2004 онд 237 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн.

2004 оны эцсийн байдлаар 1991 оноос хойш Монгол Улсад ЕХ-ны орнуудаас дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулттай 320 компани нийт 81,7 сая ам. долларын шууд хөрөнгө оруулалт хийгээд байна.

Хөрөнгө оруулалтыг улс тус бүрээр авч үзвэл (ам.доллараар): Их Британи-28,8 сая, Португаль-3,5 сая, Итали-10,8 сая, Герман-8,7 сая, Чех-4,8 сая, Нидерланд-4,6 сая, Белги-2,7 сая, Австри-2,0 сая, Польш-1,8 сая, Люксембург-1,8 сая, Унгар-1,2 сая, Франц-327 мянга, Кипр-244 мянга, Словак-197 мянга, Дани-90 мянга, Испани-60 мянга, Грек-49 мянга, Ирланд-46 мянга, Финланд-20 мянга, Эстони-17 мянга, Швед-13 мянга, Латви-10 мянга.

ЕХ-ны нийт хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах салбарт нийт 16 компани 22,9 сая ам.доллар, банк, санхүүгийн үйлчилгээний

салбарт 11 компани 19 сая гаруй ам.доллар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт 31 компани 3,9 сая ам.доллар, худалдаа, нийтийн хоолны чиглэлээр 81 компани, 9,6 сая ам.доллар, ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын салбарт 17 компани 4,5 сая ам доллар, харилцаа холбооны салбарт 1 компани 4 сая ам доллар, хөнгөн үйлдвэрийн салбарт 8 компани 2,1 сая ам долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Сүүлийн жилүүдэд ЕХ, Монгол Улсын харилцаа улам өргөжиж байна. 2005 онд Монгол улс ЕХ-ны хооронд хийсэн хэлэлцээний дагуу манай улсын Үндэсний аж үйлдвэрийн үйлдвэрлэсэн сүлжмэл эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүн зэрэг 7200 орчим төрлийн бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд гаалийн хөнгөлөлттэй нөхцлөөр оруулах шийдвэр гаргасан нь манай улсын үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр болох сайхан боломж нээж байна.

Ашигласан материал

1. Р.Жамц, Монгол Германы харилцаа: эрт эдүгээ, УБ, 2003 он
2. Ц.Лхам, Монгол Улс, Европын Холбооны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны зарим асуудалд, УБ, 2004 он